



# “ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ХОЁР-ҮЕ ШАТТАЙ ЗЭЭЛИЙН ТӨСӨЛ”-ИЙН ТАНИЛЦУУЛГА



## 1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Япон улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр санхүүжиж буй “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, Байгаль орчныг хамгаалах Хоёр-үе шаттай зээлийн төсөл”-ийн хоёр дахь шат 2011 оны 6 сараас эхлэн дараах хоёр чиглэлээр хэрэгжиж байна. Үүнд:

1. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх
2. Байгаль орчныг хамгаалах

Төслийн зорилго:

- Ядуурлыг бууруулж, тогтвортой хөгжлийг дэмжих
- Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд урт хугацааны санхүүгийн дэмжлэг үзүүлж хувийн хэвшлийг хөгжүүлэх
- Байгаль орчныг хамгаалах, агаарын бохирдлыг бууруулах
- Төсөлд оролцогч банкнууд болон ЖДҮ бизнес эрхлэгчдийг чадавхжуулах

Энэхүү төслийн хүрээнд шалгуур, шаардлага хангасан ААН-ийн нийгэм эдийн засаг, байгаль орчныг хамгаалах ач холбогдол бүхий бизнесийн төслүүдийг хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлнэ. 2022 оны байдлаар төслийн үндсэн зээлийн эх үүсвэр дууссан боловч эргэн төлөлтийн сангаас нэг зээл хүсэгчид 800,000,000 төгрөг хүртэлх буюу түүнтэй тэнцэх хэмжээний ам.долларын дүнтэй төслийн зээлийг гэрээт банкнуудаар дамжуулан олгож байна.

## 2. ЗЭЭЛДЭГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Монгол улсад бүртгэлтэй, үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байх
- Монгол талын хувийн өмч давамгайлсан (51%≤) байх
- Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн шаардлагыг хангасан байх
- Зээлээр хэрэгжүүлэх төслийн санхүүгийн хөрөнгө оруулалтын дотоод өгөөж 13% ба түүнээс дээш байх
- Зээлийн сайн түүхтэй байх
- Төслийн нийт санхүүжилтийн 20 ≤хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх чадвартай байх
- Байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх

## 3. ЗЭЭЛ ОЛГОХ НӨХЦӨЛ

ХҮШЗТ-ийн зээл нь ААН-д дэд-төслийн зээл болон очихдоо нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээ 25,000,000-800,000,000 төгрөг, эргэн төлөх хугацаа 3-10 жил, үндсэн зээлээс чөлөөлөх хугацаа 0-36 сар, жилийн хүүгийн хэмжээ төгрөгийн зээлийн хувьд 6.0%, ам.долларын зээлийн хувьд 7.44%-тай байх нөхцөлтэй байна. Мөн төслийн нийт өртгийн 20-иос багагүй хувийг зээлдэгч өөрийн хөрөнгөөс гаргах бөгөөд төсөл нь техник, эдийн засгийн хувьд хэрэгжих боломжтой, эрүүл ахуй, байгаль орчны стандартад нийцсэн, 13 хувиас

доошгүй хөрөнгө оруулалтын өгөөжтэй, өрийн үйлчилгээний харьцаа 1.3-аас их байх зэрэг бусад шалгуур үзүүлэлтүүдийг хангасан байх шаардлагатай.

#### 4. ЖДҮ-ИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ЗЭЭЛ

Хот, хөдөө орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа жижиг, дунд бизнес эрхлэгчдийн дор дурдсан бодлогын тэргүүлэх чиглэлийн төслүүдийг санхүүжүүлнэ. Үүнд:

- Импортыг орлуулах, экспортыг дэмжих
- Дэвшилтэт технологи нэвтрүүлэх
- Технологийн дамжлагатай, нэмүү өртөг шингээсэн
- Ажлын байр нэмэгдүүлэх
- Нийгэм, эдийн засгийн ач холбогдол бүхий бусад боловсруулах чиглэлүүд болно.



#### 5. БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨСЛИЙН ЗЭЭЛ

Байгаль орчныг хамгаалах бодлогын чиглэлийн ач холбогдол бүхий дараах төслүүдийг санхүүжүүлнэ. Үүнд:

1. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлийн төсөл
2. Хог хаягдал дахин боловсруулах чиглэлийн төсөл
3. Цөлжилт, газрын доройтлыг бууруулах, ойжуулах, ногоон байгууламж байгуулах төсөл
4. Байгалийн нөөцийн хэмнэлттэй хэрэглээг дэмжих (ой, ус), ойн нөөцийг орлох технологи нэвтрүүлэх төсөл
5. Хөрсний болон усны бохирдлыг арилгах, сайжруулах, хамгаалах төсөл



#### 6. ТӨСӨЛД ХАМРАГДАХ ШАТ ДАМЖЛАГА

Төслийн үйл ажиллагааны бүтцийн дагуу дэд-төслийн зээлийг дараах шат дамжлагаар олгодог. Үүнд:

1. Зээл хүсэгч төслөө бичиж, зээлийн хүсэлтээ гэрээт банканд гаргана;
2. Банк төслийн болон өөрийн банкны шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг шалгаж, зээлийн судалгааг хийсний дараа тухайн банкны зээлийн хороогоор эцэслэн батлуулна;
3. Банк нь төслийн дэд-төслийн зээлийн өргөдлийг бөглөж, ТХН-д хүргүүлнэ;
4. ТХН нь банкнаас ирүүлсэн зээлийн өргөдлийг судалж, үнэлгээний хуудсыг бөглөн дэд-төслийг Төслийн удирдах хороонд (ТУХ) танилцуулна;

5. ТУХ нь ЗГ-аас баримталж буй хөгжлийн бодлоготой дэд-төсөл нь нийцэж байгаа эсэх талаар бодлогын хэлэлцүүлэг хийж, дэмжсэн тохиолдолд дэд-төслийн санхүүжилтийг банканд олгоно;
6. Банк төслийн санхүүжилтийг эцсийн зээлдэгчид олгож, төслийн хяналт тавьж ажиллана.

#### 7. ТӨСЛИЙН НИЙТ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Төслийн нийт үр дүн 2022 оны байдлаар хот, хөдөөгийн ЖДБ эрхлэгчдийн 934 бизнесийн төслийг 341 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлж нийт 26,700 гаруй ажлын байр (шинээр бий болсон ажлын байрны тоо 15,600, хадгалагдсан нь 11,100) бий болсон байна. Төсөлд нийт 21 аймаг бүрэн хамрагдсан бөгөөд 2022 оны 10-р сарын байдлаар олгосон нийт зээлийн 61.4 хувь нь Улаанбаатар хотод, 38.6 хувь хөдөө орон нутагт ноогдож байна.